

Энэ бол Ахаб хаан Израилийг захирч байх үед болсон явдал ажээ.

Ахаб хаан Бурханд итгэдэггүй бөгөөд харин Баал шүтээнд мөргөдөг байв.

Яг энэ үед Бурхан Израильчууд уруу эш үзүүлэгч Елиаг илгээв.

Елиа бол Бурханы үгийг ард түмэнд дамжуулдаг хүн байв.

Нэгэн өдөр, Бурхан Елиад Зерафат уруу оч гэж тушаав. Тэнд нэгэн бэлэвсэн эмэгтэйтэй үулзах болно гэв.

Ингээд Елиа хүрэх газраа очтол модны мөчир түүж байгаа эмэгтэйтэй таарчээ.

Тэр эмэгтэй нөхрөө алдсан бэлэвсэн эмэгтэй байлаа. Елиа, Зерафатын бэлэвсэн эмэгтэйд ингэж хэлжээ.

“Надад уух ус, зүсэм талх авчирж өгөөч.” Тэр эмэгтэй Елиаг хараад Бурханы явуулсан хүн гэж мэджээ.

Харин тэр маш ядуу байсан учраас Елиагийн гүйсан зүйлийг өгөх хэцүү байлаа.

Гэхдээ Зерафатын бэлэвсэн эмэгтэй, Елиагийн хэлснээр хийжээ.

Гэтэл Израильд болсон гурван жил зургаан сар үргэлжилсэн ган ганчиг тайлагдах үе хүртэл бэлэвсэн эмэгтэйн гурил болон тосны сав дүүрэн байжээ. Тэр эмэгтэйн гэрт Бурханы ерөөл буусан нь тэр байлаа.

Гэтэл нэгэн өдөр бэлэвсэн эмэгтэйд гунигтай зүйл тохиолджээ.

Эв эрүүл байсан хүү нь өвчний улмаас гэнэт нас барсан байлаа.


Эмэгтэй Елиад болсон байдлыг хэлээд цурхиран үйлжээ.

Елиа үхсэн хүүг дээд давхрын өрөөнд оруулж хэвтүүлээд Бурханд хандан зарбирчээ.

Гэтэл Бурхан, Елиагийн залбирлыг сонсоод үхсэн хүүг амь оруулсан байжээ.

Бэлэвсэн эмэгтэй хүүгээ хараад чанга гэгч нь тэврэн үйлж гарав.

Зерафатын бэлэвсэн эмэгтэй Бурханд талархсаар байв.





Үйл ажиллагаа 1.

Бэлэвсэн эмэгтэйд байсан хамгийн сүүлчийн гурил болон тосыг өнгөөр ялган будаж, хайчлаад наагаарай.

Жишээ зураг



Тэгэхэд эмэгтэй Елиад —Одоо
л би таныг Бурханы хүн гэдгийг
мэдэж, таны аманд буй ЭЗЭНИЙ
үг үнэн болохыг ойлголоо гэж
хэлжээ. (1Хаад 17:24)

Хэрэглэгдэх материал: цавуу, хайч, өнгийн харандаа

а. Израиль ард түмнийг захирч байсан хаан хэн байсан бэ?

б. Бурханы илгээсэн эш үзүүлэгч хэн байсан бэ?

с. 1Хаад 17:15-24 эшлэлийг уншаад хариулаарай. Бэлэвсэн эмэгтэйн хүүд юу тохиолдсон бэ?

● Дараах эшлэлийг уншаад, цээжлээрэй. (1Хаад 17:24)

Одоо л би таныг Бурханы хүн гэдгийг мэдэж,
таны аманд буй ЭЗЭНий үг үнэн болохыг ойлголоо гэж хэлжээ.